

## МОНГОЛ УЛСААС БНХАУ-Д СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД С.АМАРСАНААГИЙН “ӨНӨӨГИЙН ХЯТАД” – Сэтгүүлд өгсөн ярилцлага

*1. Ноён Элчин сайдаа, ярилцлагаа Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн БНХАУ –д хийсэн Төрийн айлчлалаас эхлэх саналтай байна. Та албан ёсны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орсны хувьд энэ удаагийн дээд хэмжээний уулзалтын онцлог, хэлэлцсэн асуудлууд, энэхүү айлчлалын гол үр дүн, ач холбогдлын талаар ярина уу?*

**- Юуны өмнө ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс хятад судлалын чиглэлийн бие даасан “ӨНӨӨГИЙН ХЯТАД” сэтгүүлийг гаргаж буй явдалд баяр хүргэмээр байна. Мөн энэхүү шинэ сэтгүүлийн анхны дугаартаа намайг урьж оролцуулж буй явдалд талархал илэрхийлье.**

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн 2004 онд БНХАУ –д хийсэн Төрийн айлчлал амжилттай болж өнгөрлөө. Энэхүү айлчлал нь 2003 онд хоёр орны Төрийн тэргүүн нар Улаанбаатар хотноо уулзан хоёр талын хооронд **сайн хөршийн, харилцан итгэлцсэн, түншлэлийн харилцааг** тогтоож хөгжүүлэхээр санал нэгтэй тохиролцсоны дараа хийгдэж буй анхны дээд хэмжээний айлчлал, уулзалт гэдгээрээ онцлогтой юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ удаагийн айлчлал нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг шинэ зуунд хөгжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсний дээр хоёр улсын хооронд **сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг** хоёр талын хүчин чармайлтаар хөгжүүлж байгааг бүрэн дүүрэн нотолсон юм. Айлчлалын үеэр хоёр орны Төрийн

тэргүүн нар уулзаж хэлэлцээ хийсэн бөгөөд энэхүү уулзалт, хэлэлцээний үеэр хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа болон харилцан сонирхсон бусад асуудлаар санал солилцов. Монгол Улсын Ерөнхийлөгчид мөн БХАТИХ – ын Байнгын Хорооны дарга У Бангуо, БНХАУ –ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэн Зябао, БНХАУ –ын дэд дарга Зэн Цинхун нар бараалхсан. Эдгээр уулзалт, хэлэлцээний үеэр хоёр орны удирдагчид Монгол, Хятадын харилцааг улс төр, эдийн засаг болоод бүхий л салбарт цаашид урт удаан хугацаанд тогтвортой бөгөөд өргөжүүлэн хөгжүүлэх талаар ярилцаж нэгдмэл байр суурьтай байгаагаа илэрхийлсэн нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам эрчимтэй хөгжүүлэхэд таатай нөхцөл бололцоог бий болгож байгаад айлчлалын гол үр дүн, ач холбогдол оршино. Түүнчлэн хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн Гэрээ, Хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд хятадын тал манай талаас хүлээн авч сургах оюутны тоог нэмэгдүүлэх, буцалтгүй тусламж шинээр олгох болсон зэрэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн айлчлалын шууд үр дүн гэж үзэж болно.

*2. Өнгөрсөн 2003 оны 6 дугаар сард БНХАУ –ын дарга Ху Жиньтаогийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр гаргасан Хамтарсан мэдэгдэлд хоёр тал сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа тогтоон хөгжүүлэхээр тохирсоны дагуу манай Ерөнхийлөгчийн энэ удаагийн айлчлал ч дээрх заалтын хэрэгжилтэнд*

зохих хувь нэмрээ оруулсаныг Та дурдлаа. Хоёр орны харилцааны онцлог, тэргүүлэх чиглэлүүдийн талаар тодруулна уу. Өөрөөр хэлбэл Монгол, Хятадын харилцааны хэтийн төлөвийг хэрхэн төсөөлж байна вэ?

- Хоёр улсын хооронд сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг тогтоон хөгжүүлж буй тухай би өмнө нь дурьдлаа. Өөрөөр хэлбэл хоёр улсын харилцаа хөгжлийн шинэ шатанд дэвшин орлоо. Энэхүү шинэ үе шатан дахь хоёр улсын харилцаа нь Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн тэмдэглэж хэлсэнчлэн:

- Хоёр улс эрх тэгш, бие биеийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх зарчимд тулгуурласан улс төрийн харилцан итгэлцэл,

- Бие биеийн хөгжлийн замын сонголтыг хүндэтгэх, хөгжлийн хүчин чармайлтыг дэмжих зарчимд тулгуурласан худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагаа, соёл, хүмүүнлэгийн өргөн хүрээтэй харилцаа,

- Бүс нутгийн хамтын ажиллагаа, харилцан итгэх явдлыг бэхжүүлэх чиглэлд идэвхитэй хамтран ажиллах, бүс нутгийн интеграцийн үйл хэрэгт хамтран оролцох явдал юм.

Үндсэндээ эндээс сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааны шинэ үе шатан дахь хоёр улсын харилцааны онцлог, тэргүүлэх чиглэл юу байх ёстой вэ гэдэг үндэслэл харагдаж байна.

Монгол-Хятадын харилцааны хэтийн төлөвийг өөдрөгөөр төсөөлж байна. Учир нь ийнхүү итгэл үнэмшилтэйгээр өргөжин хөгжихөөр төсөөлөх улс төрийн үндэс суурь нэгэнт тавигдаж улам бүр бат бөх болж байна. Иймд бид хоёр талын болон бүс нутгийн хүрээнд өргөн хүрээтэй, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, бие биеийн хөгжлийн

зорилтуудыг харилцан дэмжих явдалд улам бүр түлхүү анхаарлаа тавих нь зүйтэй юм.

3. Манай хоёр орны хооронд шийдвэрлэгдээгүй улс төр, эдийн засгийн томоохон асуудлууд, ноцтой маргаан, зөрөлдөөн байхгүй. Гэхдээ аливаа улс орон өөрийн эрх ашгаа хамгаалах, гадаад таатай орчин бүрдүүлэх, түүнийгээ улам бататгахыг эрмэлздэг. Мөн түүнчлэн Хятад улс бол дэлхийн хэмжээнд бодлогоо явуулдаг, эдийн засаг нь өдрөөс өдөрт өргөжин тэлж буй их гүрэн. Харин Монгол Улс бол улс төр, эдийн засгийн аюулгүй байдал нь гадаад орчин, ялангуяа хоёр их хөршөөс ихээхэн хамааралтай боловч геополитикийн үүднээс харьцангуй чухал байршилтай жижиг, буурай орон. Эдгээр нөхцөл байдалтай уялдан Монгол, Хятадын харилцаанд анхаарвал зохих ямар асуудлууд байдаг вэ? Энэ талаар таны үзэл бодлыг сонсмоор байна.

- Үнэхээр манай хоёр орны хооронд маргаантай, шийдэгдэж болшгүй томоохон асуудлууд байхгүй. Мэдээжээр санал зөрөөтэй, байр суурь харилцан адилгүй байх асуудал гардаг. Энэ бүхнийг бие биенээ харилцан хүндэтгэж, харилцан ойлголцсоны үндсэн дээр яриа хэлэлцээний замаар амжилттай шийдвэрлэж ирсэн. Танай сэтгүүлийн асуултанд Монгол Улс улс төр, эдийн засгийн аюулгүй байдлын хувьд хоёр хөршөөсөө ихээхэн хамааралтай тухай хөндөгдлөө. Миний бодлоор энэхүү хамаарлыг дарамт шахалт, эсхүл гадаад таагүй орчин гэж ойлгохын оронд харин хамтран ажиллах, хөгжлийн хурдаа түргэсгэх гадаад таатай орчин, бас нэгэн боломж гэж үзвэл зүйтэй юм. Угаасаа даяаршлалын үйл явцыг даган харилцан хамааралгүй зүйл гэж байхгүй болж байна. Улс орнууд их бага гэлтгүй бие биенээсээ харилцан хамааралтай болж байна. Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа

сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж буйгаас үүдэн манай эдийн засаг Хятадын зах зээлээс хэт хараат болж байна гэх санаа зовнил манай зарим хүмүүст бий болсон. Энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ч мөн нилээд хөнддөг. Зөвхөн нэг талаас нь ийнхүү өрөөсгөл харж болохгүй юм. Нөгөө талаас нь энэхүү том эдийн засагтай манай эдийн засаг зэрэгцэн оршиж буй нь мөн ямар боломж өгч байна, бид яах ёстой вэ гэдэг талаас нь сайтар нухацтай бодож боловсруулах ёстой болов уу. Манай эрдэмтэн судлаачид, ялангуяа хятад судлаачид энэ талаар өргөн хүрээтэй том хэмжээний судалгаа цаашдаа хийвэл ихээхэн хэрэгтэй юм.

4. *Хятад улс бол дэлхийн хамгийн их хүн амтай, хамгийн өндөр хурдтай хөгжиж буй Азийн орон, мөн манай хоёр том хөршийн нэг. Дэлхий дахинд ч Хятадын өөрчлөлт шинэчлэлтийг анхааралтай ажиглаж байна. Ноён элчин сайд энэ оронд ажиллах хугацаандаа төрсөн сэтгэгдэл, Хятадын өөрчлөлт, шинэчлэлийн талаар үзэл бодлоосоо хуваалцана уу.*

- Миний бие Элчин сайдаар ажиллах хугацаа хоёр улсын харилцаа улам бүр өрнөн хөгжиж түншлэлийн шинэ шатанд дэвшин орсон цаг үетэй давхцсанд би баяртай байдаг. Шинэчлэл, нээлттэй хаалганы бодлого хэрэгжүүлж эхэлсэн хорь гаруй жилийн хугацаанд Хятад орон нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх тал дээр асар их амжилт олсныг хэн бүхэн мэднэ. Юуны өмнө энэхүү шинэчлэл, өөрчлөлтийн бодлогоо бүх талаас нь тунгаан бодож алсыг харсан стратегийн үндсэн дээр хэрэгжүүлж байна гэж надад бодогддог юм. Нийгэм, эдийн засгийн бодлогоос авахуулаад улс орны удирдлага нэг үеэс нөгөөд шилжих үйл явц тэр бүгд нэг л цогцоор шийдэгдэж байна гэлтэй. Мэдээжээр өөрчлөлт, шинэчлэлтийг хэрэгжүүлэх явцад тодорхой хэмжээнд хүндрэл бэрхшээл, зарим үед авч

хэрэгжүүлж буй арга хэмжээний сөрөг үр дагавар гарч байгаа тухай мэдээлэл их байдаг. Энэ бүхнийг цаг тухайд нь засч залруулах талаар ч мөн тууштай арга хэмжээ авч байна. Хамгийн гол нь Хятадад явагдаж буй энэхүү өөрчлөлт шинэчлэл, хэрэгжүүлж эхлээд буй томоохон төсөл төлөвлөгөөнүүд нь мөн манай хөгжилд ч түлхэц өгөх учиртай. Тухайлбал Хятадын тал чухалчилж буй баруун бүс нутгаа хөгжүүлэх стратеги болон хуучин аж үйлдвэрийн гол бааз нь болох Зүүн Хойд Хятадыг сэргээн хөгжүүлэх төлөвлөгөө зэргийг дурьдаж болно. Нэгэнт л харилцан хамааралтай дэлхий ертөнцөд оршиж байгаа тул бид өөрийн орны баруун болон зүүн хэсгийг хөгжүүлэх зорилт төлөвлөгөөгөө хөршийнхөө энэ том төсөл төлөвлөгөөтэй яаж хэрхэн уялдуулах талаар бодох хэрэгтэй. Энэхүү хамтын ажиллагаа нь манай хөгжилд дорвитой түлхэц, Хятадын хөгжилд нэмэр хандив болж болох бололцоо бий гэж би үздэг. Энэ асуудлаар манай хоёр орны эрдэмтэд тодорхой хэмжээгээр судалж, санал болгож бичсэн зүйлүүд байдаг. Цаашдаа ч үргэлжлүүлэн судалвал ихээхэн бодитой сэдэв, манай орны хөгжлийн нэгдмэл үзэл баримтлалд тодорхой хувь нэмэр болох нь ойлгомжтой.

5. *Элчин сайд хүн бол хоёр талын харилцааг холбох гүүр болдгийн хувьд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд хамгийн идэвхитэй оролцдог болов уу. Монгол улсыг төлөөлөн Хятад оронд суугаа Элчин сайдын хувьд энэ орныг хэрхэн судлах, ямар асуудалд анхаарвал зохих талаар таны үзэл бодол, санал зөвлөгөө манай хүрээлэнгийн болон хятад судлалын нийт мэргэжилтнүүдийн эрдэм судлалын ажилд чухал хувь нэмэр болох байх гэж бодож байна.*

- Манай хятад судлаачид юуны өмнө хөрш орноо судлах, өөрийн орны өргөн олон нийтэд Хятад орныг зөв таниулах талаар

ихээхэн үүрэг гүйцэтгэж ирснийг тэмдэглэхэд таатай байна. Монгол дахь хятад судлалыг хөгжүүлэх үйлсэд танай хүрээлэн, хамт олон чухал хувь нэмэр оруулж байна. Танай хүрээлэнгээс санаачлан хятад судлалын чиглэлээр анхны бие даасан “Өнөөгийн Хятад” сэтгүүлийг эрхлэн гаргаж байгаа нь үүний нотолгоо хэмээн үзэж байна. Та бүхэнд хятад судлалын талаар санал зөвлөгөө өгнө гэдэг магадгүй илүүц байж болох ч цаашдын судалгааныхаа ажилд санаа авахуйц байж магадгүй гэсэн үүднээс дараахийг хэлье. Өмнө нь би хоёр ч удаа тодорхой асуудлаар манай хятад судлаач эрдэмтэдийг судалгаагаа улам өргөжүүлэхийг санал болгосон. Юуны өмнө манай хятад судлал монгол, хятадын харилцааны өнгөрсөн түүх, өнөөгийн харилцаанаас гадна ирээдүйд чиглэсэн байх хэрэгтэй юм. Хийж буй судалгааны ажил улс орны хөгжлийн зорилтуудыг шийдэхэд аль болох нэмэр хандив оруулахуйц, хөршийнхөө хүчин зүйлийг хэр зөв оновчтой ашиглах вэ гэсэн талаас нь бодитой санал дэвшүүлсэн байвал зүгээр юм. Мэдээжээр үүний тулд бас өмнөд хөршийнхөө дотоод, гадаад бодлого, ялангуяа манайтай хил залгаа бүс нутагт нь өрнөж буй хөгжлийн үйл явцыг анхааралтай ажиглаж судлах шаардлагатай. Ийнхүү судлахдаа хятадын болон гадны мэдээлэл, судалгааны эх сурвалж ашиглах нь зайлшгүй. Гэхдээ ийнхүү олон талын мэдээлэл ашиглан судлахдаа өөрийн эрх ашгийн үүднээс дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг байх нь туйлын чухал юм. Хятад судлал өндөр хөгжсөн орнууд дахь хятадын судалгаа өөрийн зорилго чиглэлтэй. Үүнтэй адилаар монгол дахь хятад судлал мөн өөрийн орны эрх ашиг, онцлогтой уялдсан өөрийн гэсэн зорилго, чиглэлтэй байх ёстой гэж би хувьдаа боддог.

6. Монгол улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ бол Монгол улсаас гадаад орнуудад ажиллаж байгаа ЭСЯ-дын дотроос хамгийн

том, хамгийн их ачаалалтайд тооцогдох байх. Та хамт олныхоо талаар, ЭСЯ-ныхаа үйл ажиллагааны талаар товч сонирхуулахгүй юу?

- Монгол улсаас гадаад орнуудад ажиллаж байгаа ДТГ-уудын дотроос манай ЭСЯ ажлын ачаалал, ажиллагсадын тоо, өөрийн эзэмшиж байгаа хөрөнгийн хэмжээгээрээ нэлээд том ЭСЯ-нд орно. Манай хамт олон мэдлэг мэргэжил, ажил, амьдралын дадлага туршлага сайтай дипломат ажилтнууд олонтойгоос гадна Монгол улсын төр, засгаас хүлээлгэсэн итгэл найдвар, хариуцуулсан ажил, үүргийг нэр төртэй биелүүлэх бүрэн бололцоотой гэж итгэж найдаж ажиллаж байдаг. Манай хамт олны ажил үйлс амжилттай явагдах нэг гол үндсэн нөхцөл бол өнөөдрийн цаг үед Монгол, Хятадын харилцаа, хамтын ажиллагааны төлөв байдал нэн таатай байгаа нь манай хамт олныг ажил төрлөө амжилттай хийж гүйцэтгэхэд урам өгч бид бүхэн их өөдрөг сэтгэлтэйгээр ажилладаг юм. Энэ бол бид бүхний ажиллах урам зоригийг нэмэгдүүлсэн том хүчин зүйл бөгөөд бид ч энэхүү таатай нөхцөл бололцоог аль болох бүрэн дүүрэн, үр өгөөжтэй ашиглахын төлөө хүч чармайлт гарган ажиллаж байна. Дээр би дурьдсан манай ЭСЯ-ны хамт олон өндөр ачаалалтай ажиллаж байна. Заримаас нь тодруулж дурьдвал, тус ЭСЯ манай улсаас хөрш оронтойгоо явуулдаг бодлогыг бүхэлд нь хариуцан ажилладгаас гадна өнөөдрийн байдлаар Бээжингээс Монгол улсыг 63 орны Элчин сайд болон НҮБ-ын 5 суурин төлөөлөгчийн газар хавсран ажилладаг нь манай хамт олон ямархуу ажлын ачаалалтай ажилладаг нь тодорхой ойлгогдох болов уу гэж бодож байна. Эндээс дүгнэлт хийж үзвэл бид бүхний ажиллаж байгаа БНХАУ-ын нийслэл Бээжин хот Монгол улсын гадаад харилцаанд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг нь тодорхой юм.

Энэхүү ажлын ачааллыг хүнд гэлгүйгээр идэвхи чармайлт гарган ажиллаж улсынхаа нэр төрийг зохих түвшинд нь хадгалан хамгаалж дээшлүүлж байгаа хамт олноороо Элчин сайд би бахархаж явдаг. Цаашид ч энэхүү эрч хүчээ алдахгүйгээр улам эрч хүчтэй ажиллах тийм бололцоо манай хамт олны дунд тогтсон гэдэгт итгэлтэй байна. Манай хамт олон Монгол улсынхаа төр, засгаас хүлээлгэсэн аливаа ажил үүргийг нэр төртэй биелүүлж бүхий л бололцоогоо хоёр орны болон хавсран суугаа орнуудын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө болоод Монгол улсынхаа иргэдийн эрх ашгийг суугаа болон

хавсран суугаа орнуудад хамгаалах үүргээ нэр төртэй биелүүлж ажиллах болно.

*Манай хүсэлтийг хүлээн авч, цаг зав гарган сонирхолтой ярилцлага өгсөн ноён Элчин сайд С.Амарсанаа танд гүн талархал илэрхийлэх ялдамд танд болон таниар дамжуулан танай ЭСЯ-ны нийт хамт олонд эрүүл энх, ажлын амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе!*

**Ярилцлага хийсэн: ШУА-ийн  
Олон улс судлалын хүрээлэнгийн  
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
“ӨНӨӨГИЙН ХЯТАД” сэтгүүлийн  
орлогч эрхлэгч Д.Шүрхүү( Ph.D)**